Ногооннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Ногооннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандарт, журмын дагуу шинэчлэгдсэн байна.

Улсын төсвөөс санхүүждэг байсан Ногооннуур сумын Сум дундын эмнэлэг нь бүтцийн өөрчлөлтөөр 2021 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс сумын Төсвийн төвлөрүүлсэн захирагчийн мэдэлд шилжиж, сумын Эрүүл мэндийн төв болж өөрчлөгдөн, Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангийн нэгтгэлд орсон байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт дотоод аудитын албанаас 2021 онд Ногооннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад шалгалт хийгдээгүй байна.

Ногооннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад үр нөлөөтэй байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 5,094.9 сая төгрөгөөс 1 хувиар буюу 50.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 35.7 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 299.1 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 273.8 сая төгрөг болж, 25.3 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө				
Банканд байгаа бэлэн мөнгө	299.1	273.8	-25.3	
Замд яваа мөнгөн хөрөнгө				
Хадгаламж				
Дүн	299.1	273.8	-25.3	

Эх сурвалж: Ногооннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 273.8 сая төгрөг болж 25.3 сая төгрөгөөр буурсан байна. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 273.8 сая төгрөгийн 110.8 сая төгрөг нь Орон нутгийн хөгжлийн сангийн, 29.7 сая төгрөг нь Сум хөгжүүлэх сангийн, 117.0 сая төгрөг нь орон нутгийн төсвийн ерөнхий орлогын, 2.5 сая төгрөг нь Эргэлтийн эмийн сангийн, 13.6 сая төгрөг нь байгаль орчныг хамгаалах сангийн, 130.7 сая төгрөг нь төрийн сан дахь орон нутгийн орлогын дансны үлдэгдэл байна.

Аудитын илрүүлэлт:

Аудитаар мөнгөн хөрөнгөтэй холбоотой зөрчил гараагүй байна.

3.5.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт

Богино хугацаат хөрөнгө оруулалт дансны оны эхэн ба эцэст үлдэгдэлгүй байна.

3.5.3 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 273.1 сая, эцсийн үлдэгдэл 300.4 сая төгрөг болж, 27.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2. Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	13.1	3.0	-10.1
Төлбөртэй үйлчилгээний авлага		43.7	43.7

Татаас, санхүүжилтийн авлага			-
Зээлийн хүүгийн авлага			
Бусад авлага		15.0	15.0
Зээлийн авлага	259.9	238.7	--21.2
Дүн	273.1	300.4	27.3

Эх сурвалж: Ногооннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт авлагын 79.4 хувийг Сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага, 20.6 хувийг төсөвт байгууллагын авлага эзэлж байна.

Сум хөгжүүлэх сангийн зээлийн авлагын үлдэгдэл 238.7 сая төгрөг байгаа нь тайлант оны зээлийн эргэн төлөлтийн хэмжээгээр буурсан байна.

Төлбөртэй үйлчилгээний авлага 43.7 сая төгрөгөөр өссөн нь Эрүүл мэндийн төвийн Эрүүл мэндийн даатгалын сангаас авах Ковид-19 цар тахлын улаан бүсд ажилласан ажилчдын урамшуулал болон бараа үйлчилгээний зардлын авлага байна.

Бусад авлагын үлдэгдэл 15.0 сая төгрөгөөр өссөн нь Хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн авлага бөгөөд аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/1075 тоот захирамжаар төсөвт хийсэн зохицуулалтын дагуу “Багшийн хөгжлийн танхим” ажиллуулахад шаардлагатай техник хэрэгсэл авахад зориулж багаж, техник хэрэгсэл зардлын төсөвт суусан 15.0 сая төгрөгийг “Чарж” ХХК-ний дансанд хөрөнгө нийлүүлэхээр шилжүүлж, шинээр авлага үүсгэснээс шалтгаалжээ.

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай авлага байхгүй байна.

3.5.4 Урьдчилгаа

Урьдчилгаа данс оны эхэн ба эцэст үлдэгдэлгүй байна.

3.5.5 Урт хугацаат хөрөнгө оруулалт

Урт хугацаат хөрөнгө оруулалтын данс оны эхэн ба эцэст үлдэгдэлгүй байна.

3.5.6 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 435.8 сая, эцсийн үлдэгдэл 501.8 сая төгрөг болж, 66.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	13.9	26.0	12.1
Хангамжийн материал	364.4	410.1	45.7
Мал амьтад	57.4	65.6	8.2
Дүн	435.7	501.7	66.0

Эх сурвалж: Ногооннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдэл 501.7 сая төгрөг болж 66.0 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд сумын төсөвт байгууллагууд төсвийн хөрөнгөөр 691.8 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч, 70.7 сая төгрөгийн материалыг үнэгүй хүлээн авч данс бүртгэлд тусгаж, үйл ажиллагаандаа 699.8 сая төгрөгийн бараа материалыг зарцуулж, 2.7 сая төгрөгийн материалыг акталсантай холбоотой байна.

Бараа материалын нийт үлдэгдлийн 43.5 сая төгрөг нь Засаг даргын тамгын газрын, 1.3 сая төгрөг нь ИТХ-ын, 282.7 сая төгрөг нь Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн, 19.2 сая төгрөг нь 2 дугаар сургуулийн, 13.5 сая төгрөг нь 3 дугаар сургуулийн 15.0 сая төгрөг нь 4 дүгээр сургуулийн, 31.0 сая төгрөг нь Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн, 12.8 сая төгрөг нь 2 дугаар цэцэрлэгийн, 68.2 сая төгрөг нь Эрүүл мэндийн төвийн, 8.9 сая төгрөг нь Соёлын төвийн, 5.6 сая төгрөг нь Эргэлтийн эмийн сангийн үлдэгдэл байна.

Аудитын илрүүлэлт:

1. Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэг өмнөх оны аудитаар 1118.0 мянган төгрөгийн 172 кг махыг хүнсний талноос илүү зарлага гаргасан зөрчлийг нягтлан бодогч нярав нараар нөхөн төлүүлж, цэцэрлэгийн дансанд оруулахаар төлбөрийн акт тогтоосныг барагдуулаагүй тул зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлсэн.

2. Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль дотуур байрны хүүхдийн хоолонд Засгийн газрын 2019 оны 450 дугаар тогтоолоор батлагдсан хүүхдийн нэг өдрийн хоолны зардлын нормыг 0.2 сая төгрөгөөр хэтрүүлэн төсвөөс хууль бус зарлага гаргасан зөрчилд төлбөрийн акт тогтоов

3. Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн санхүүгийн аудитаар бараа материалын зарим данснуудын орлого, зарлагыг 9.1 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан зөрчилд албан шаардлага хүргүүлсэн. Санхүүгийн тайланд олон жил он дамжсан 0.5 сая төгрөгийн бодитоор байхгүй малын бүртгэлийг шийдвэрлэх арга хэмжээ аваагүй, Ковид-19 цар тахлын хязгаарлалтын үед Тавалтайн постод ажилласан ажилчдын хоол хүнсэнд олгосон 0.8 сая төгрөгийн хүнсний материалыг зарцуулах талаар, захирамж, тушаал шийдвэрийг бүрдүүлж баримтжуулаагүй зөрчилд зөвлөмж хүргүүлэв.

3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 8,833.3 сая, эцсийн үлдэгдэл 8,844.7 сая төгрөг болж, 11.3 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	8672.2	8680.5	8.2
Биет бус хөрөнгө	161.1	164.2	3.1
Дүн	8833.3	8844.7	11.3

Эх сурвалж: Ногооннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 27.6 сая, үнэ төлбөргүй хандиваар хүлээн авсан 2015.5 сая төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд 164.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлж, акталсан байна. Дуусаагүй барилга дансанд хөрөнгө бүртгэгдээгүй байна. Тайланд үндсэн хөрөнгөнд нийтдээ 436.8 сая төгрөгийн элэгдэл байгуулсан байна.

Аудитын илрүүлэлт:

1. Хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн санхүүгийн тайлангаар 59.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 12.8 сая төгрөгийн бараа материалын тооллогыг зохих журмаар хийгээгүй, үндсэн хөрөнгө, бараа материалын үлдэгдлийг тооцоо хийж баталгаажуулаагүй зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 88.2 сая, эцсийн үлдэгдэл 40.8 сая төгрөг болж, 47.4 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Ажилчидтай холбогдсон өглөг	48.9	4.2	-44.7	10.3
Бараа үйлчилгээний зардлын өглөг	0			
Байгууллагад төлөх өглөг	37.4	36.6	-7.8	89.7

Хувь хүмүүст төлөх өглөг	1.9	0	-1.9	
Нийт дүн	88.2	40.8	-47.4	100.0

Эх сурвалж: Ногооннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн 10.3 хувийг ажилчидтай холбогдсон өглөг, 89.7 хувийг байгууллагад төлөх өглөг эзэлж байна. Иргэдийн төлөөлөгчдийн хурал 2.1 сая төгрөгийн, Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэг 2.1 сая төгрөгийн, Орон нутгийн хөгжлийн сан 36.6 сая төгрөгийн өглөгтэй гарсан байна.

Аудитын илрүүлэлт:

1. Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэг цалингийн зардлын хэмнэлтээс улсын баяр наадмын 5 хоногийн цалинг ээлжийн амралттай байсан албан хаагчдад нөхөж олгосны улмаас жилийн эцэст цалингаас суутгасан татварт 2103.8 мянган төгрөгийн өглөгтэй гарсан зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 9753.1 сая, эцсийн үлдэгдэл 9879.9 сая төгрөг болж, 126.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №6 Засгийн хувь оролцоо /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт -/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2389.8	2393.2	3.4	24.2
Хуримтлагдсан үр дүн	3482.1	3607.7	125.6	36.5
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3881.1	3878.9	-2.2	39.3
Дүн	9753.1	9879.8	85.1	100.0

Эх сурвалж: Ногооннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 9879.9 сая төгрөг болж 126.8 сая төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ.

Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл данс оны эцэст 3878.9 сая төгрөг болж 2.2 сая төгрөгөөр буурсан нь сумын Засаг даргын тамгын газрын актлагдсан хөрөнгөтэй холбоотой гарсан өөрчлөлт байна. Хуримтлагдсан үр дүн 3607.7 сая төгрөг болж 125.6 сая төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ.

3.5.10. Орлогын данс

Ногооннуур сум нь 2021 онд гүйцэтгэлээр орон нутгийн татварын орлогоос 222.2 сая төгрөгийн орлого оруулж, үндсэн үйл ажиллагааны орлогоос 65.4 сая төгрөгийн, туслах үйл ажиллагааны орлогоос 5.9 сая төгрөгийн, бусад орлогоос 51.7 сая төгрөгийн, тусгай зориулалтын шилжүүлгээс 3904.9 сая төгрөгийн, Эрүүл мэндийн даатгалын сангаас 79.4 сая төгрөгийн, орон нутгаас 758.0 сая төгрөгийн, нэмэлт санхүүжилтээр 173.7 сая төгрөгийн санхүүжилт хүлээн авч, үнэ төлбөргүйгээр 505.2 сая төгрөгийн хөрөнгө, бараа материалыг хүлээн авч нийтдээ 5766.5 сая төгрөгийн орлого бүрдүүлэн ажилласан байна.

Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар нийт орлого 5766.5 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 1491.8 сая төгрөгөөр буюу 35.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан төсвийн урсгал, нэмэлт санхүүжилт, орон нутгийн төсөв, үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө, бараа материал, ЭМД-ын сангийн санхүүжилт байна.

3.5.11 Зардлын данс

Ногооннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар нийт зардал 5315.2 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 220.3 сая төгрөгөөр буюу 4.3 хувиар өссөн байна.

Нийт зардлын 97 хувь нь бараа үйлчилгээний зардал, 3 хувь нь урсгал шилжүүлэг байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс, НДШ, хангамж, бараа материалын зардал, нормативт зардал, эд хогшил, урсгал засварын зардал, томилолт, зочны зардлууд 3.1-624.3 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Зардлын данстай холбоотой алдаа зөрчил илрээгүй байна.

Аудитын илрүүлэлт:

1. Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэг цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал зардлын төсвөөс зарцуулсан 0.3 сая төгрөгийн зардлыг тооцооны дансаар дамжуулахгүйгээр шууд зардлаар бүртгэж тайлагнасан, анхан шатны бүрдэл дутуу баримтаар 0.8 сая төгрөгийн ажил гүйлгээг зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн, санхүүгийн тайлангаарх бараа материалын үлдэгдэл нярвын бараа материалын тайлангийн үлдэгдлээс 0.7 сая төгрөгийн зөрүүтэй, бараа материалын зарлагын анхан шатны баримтуудыг дутуу бүрдүүлсэн, нотлох баримтууд хангалтгүй зэрэг 1.8 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлсэн.

2. Хүүхдийн 2 дугаар цэцэрлэг анхан шатны бүрдэл дутуу баримтаар 10.5 сая төгрөгийн ажил гүйлгээг зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн, санхүүгийн тайлангаарх бараа материалын үлдэгдэл нярвын бараа материалын тайлангийн үлдэгдлээс 4.2 сая төгрөгийн зөрүүтэй, бараа материалын тайлангийн зарлагын гүйлгээний анхан шатны баримтуудыг дутуу бүрдүүлсэн, зардлын нотлох баримтууд хангалтгүй зэрэг 14.7 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлэв.

3. Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль тайлант онд төсвөөс болон нэмэлт санхүүжилтээр бараа материал худалдан авах, үдийн цай, шуудан холбоо, гэрэл цахилгааны зардалд зарцуулсан нийт 21.2 сая төгрөгийн ажил гүйлгээг тооцооны данс дамжуулахгүйгээр шууд зардлаар бүртгэж тайлагнасан тул зөвлөмж хүргүүлэв.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тайлант онд Ногооннуур сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрт зориулан 5076.8 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 4735.2 сая төгрөгийг урсгал зардалд, 341.6 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 3915.4 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 665.8 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 244.6 сая төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангаас, 49.0 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 3.5 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 198.5 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Төсвийн гүйцэтгэл

Ногооннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2021 онд гүйцэтгэлээр нийтдээ 4979.1 сая төгрөгийн тусламж санхүүжилтийн орлого бүрдүүлснээс тусгай зориулалтын шилжүүлгээс 3904.9 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 767.1 сая төгрөгийн, Эрүүл мэндийн даатгалын сангаас 244.7 сая төгрөгийн, Орон нутгийн хөгжлийн сангаас 37.8 сая төгрөгийн санхүүжилт хүлээн авч, үндсэн үйл ажиллагааны орлогоос 24.7 сая төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Үндсэн үйл ажиллагааны орлогоос 24.7 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн байна. Үүний 21.2 сая төгрөг нь Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс орсон орлого байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 5020.5 сая төгрөг буюу 98.8 хувьтай байгаа нь дутуу авсан санхүүжилт, тасарсан орлоготой холбоотой байна.

Сумын орон нутгийн төсвийн орлогын талаар:

Аймгийн ИТХ-ын 2020 оны “Орон нутгийн төсөв батлах тухай” 16 дугаар тогтоолоор Ногооннуур сумын 2021 оны орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 147.0 сая төгрөгөөр баталсан байна.

Аймгийн ИТХ-ын хуралдааны “2021 оны төсөвт тодотгол хийх тухай” 2021 оны 41 дүгээр тодотголоор Ногооннуур сумын төсвийн орлогыг 147.0 сая төгрөгөөр баталж өөрчлөлт оруулаагүй байна.

Сумын ИТХ-ын 2021 оны 21 дүгээр хуралдааны тогтоолоор 2021 орлогын төлөвлөгөөг 154.6 сая төгрөгөөр буюу 7.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн орлогод 271.4 сая төгрөгийн орлого оруулж, төлөвлөгөөг 116.8 сая төгрөгөөр буюу 75.5 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт №7 Орон нутгийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Өсөлт/+/, бууралт /-/	Дүнд эзлэх хувь
I.Татварын орлого	148.6	262.9	114.3	96.8
II.Татварын бус орлого	6.0	8.5	2.5	3.2
Нийт дүн	154.6	271.4	116.8	100.0

Хувь хүний орлогын алба татвар 17.1 сая төгрөгөөр, бусад татвар 15.9 сая төгрөгөөр, байгалийн нөөц ашигласны төлбөр 61.1 сая төгрөгөөр, татварын бус орлого 23.1 сая төгрөгөөр давж, өмчийн татвар 0.5 сая төгрөгөөр тасарсан байна.

Орлогын нэр төрлөөр авч үзэхэд хөрөнгийн орлогын албан татвар 4.1 сая төгрөгөөр, бууны албан татвар 0.5 сая төгрөгөөр түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 3.1 сая төгрөгөөр, хүү торгуулийн орлого 0.8 сая төгрөгөөр тус тус тасарч, бусад орлого давж биелэгдсэн байна.

Орон нутгийн орлого төлөвлөгөөний давж биелэгдэхэд агнуурын нөөцийн төлбөр 59.4 сая төгрөгөөр, улсын тэмдэгтийн хураамж 17.0 сая төгрөгөөр, хөрөнгө борлуулсны албан татвар 15.5 сая төгрөгөөр давж, төлөвлөгдөөгүй малын тоо толгойн албан татвараас 20.6 сая төгрөгийн орлого оруулсан нь орон нутгийн орлого давж биелэгдэхэд голлон нөлөөлсөн байна.

Орон нутгийн ерөнхий орлогын 910 тоот дансанд оны эхэнд 299.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй ба Орон нутгийн орлогын 995 тоот дансаар 271.4 сая төгрөгийн татварын орлого оруулж, оны эцэст орон нутгийн төсвийн ерөнхий орлогын 910 тоот дансанд 117.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Хүснэгт №8 Төсвийн байгууллагуудын 2021 оны төсвийн зарлагын гүйцэтгэл:

/сая төгрөг/

Д/д	Байгууллагын нэр	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт
1	Сумын ИТХ	75.8	75.8	
2	Сумын ЗДТГ	459.8	459.8	
3	Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль	1683.1	1683.1	

4	Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль	259.2	259.0	0.2
5	Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль	218.1	218.1	
6	Ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль	237.1	226.8	10.3
7	Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэг	390.4	390.5	
8	Хүүхдийн 2 дугаар цэцэрлэг	424.8	424.9	
9	Соёлын төв	132.0	131.8	0.3
10	Эрүүл мэндийн төв	854.6	843.3	11.3
11	ОНХСан	341.6	244.7	96.9
12	СХС		21.3	-21.3
	Нийт дүн	5076.8	4979.1	97.7

Аудитын илрүүлэлт:

1. Төсөвт байгууллагуудаас Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгаж үзэхэд 1.1 дэх заалтад хамаарах байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад батлагдсан төсвийг ЗДТГ 14.8 сая төгрөгийн, Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль 7.1 сая төгрөгийн, 2 дугаар сургууль 0.5 сая төгрөгийн, 3 дугаар сургууль 0.6 сая төгрөгийн, 4 дүгээр сургууль 0.7 сая төгрөгийн, Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэг 0.9 сая төгрөгийн, 2 дугаар цэцэрлэг 2.5 сая төгрөгийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал зардлыг төлөвлөн зарцуулаагүй, тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй тул төсвийн шууд захирагч нарт тус тус албан шаардлага хүргүүлсэн.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Ногооннуур сумын төсөвт байгууллагууд тусламж дээд шатны төсвийн захирагчаас 89.3 сая төгрөгийн, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоор 0.2 сая төгрөгийн, төсвийн урамшуулал 84.2 сая төгрөгийн, нийт 173.7 сая нэмэлт санхүүжилт хүлээн авсан байна.

Үүнээс цалин хөлстэй холбоотой зардалд 57.5 сая, хангамж бараа материалын зардалд 9.2 сая, нормативт зардалд 18.8 сая, эд хогшил урсгал засварын зардалд 0.2 сая, томилолтын зардалд 0.9 сая, бараа үйлчилгээний бусад зардал 28.4 сая, урсгал шилжүүлэгт 57.4 сая, хөрөнгийн зардалд 1.2 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд хуулиар зөвшөөрөгдөөгүй орлого ороогүй байна

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст Ногооннуур сумын Засаг даргын 2021 оны 21 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, Орон нутгийн хөгжлийн сангийн таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний 117.5 сая төгрөгийн гүйлгээний мэдээллийг мэдээлээгүй, 133.0 сая төгрөгийн мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, Сум хөгжүүлэх сангийн 238.7 сая төгрөгийн зээлийн авлагыг талаарх мэдээллийг байршуулаагүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус ТТЗ-ийн багцад хамаарах 10 байгууллагыг хамруулан, мөн хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг шалгалаа.

Аудитын илрүүлэлт:

1. Хүүхдийн 2 дугаар цэцэрлэг нь шилэн дансанд санхүүжилтийн 392.8 сая төгрөгийн 25 мэдээллийг 0 дүнтэйгээр мэдээлсэн, 11 сарын мэдээг хугацаа хоцроож мэдээлсэн, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 17.6 сая төгрөгийн зарлагын мэдээллийг огт мэдээлээгүй, 15.0 сая төгрөгийн авлага үүсгэсэн тухай шийдвэрийг мэдээлээгүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш зарлагын 15.0 сая төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй зэргээр нийт 440.4 сая төгрөгийн зөрчил гаргаж, шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн дундаж хувь 25.0 хувьтай байна.

Өмнөх аудитаар шилэн данстай холбоотой зөвлөмж өгөгдсөн боловч зөрчлийг давтан гаргасан тул албан шаардлага хүргүүлсэн.

2. Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль шилэн дансанд 5 саяас дээш 56.8 сая төгрөгийн 4 гүйлгээг байршуулаагүй, шилэн дансны мэдээлсэн байдлын хэрэгжилтийн дундаж хувь 73.0 хувьтай гаргасан тул албан шаардлага хүргүүлсэн.

3. Эрүүл мэндийн төв 339.7 сая төгрөгийн 6 мэдээллийг хугацаа хоцроож, оны эцэст үүссэн 42.3 сая төгрөгийн авлага үүсгэсэн шийдвэрийн талаарх мэдээллийг байршуулаагүй тул зөвлөмж хүргүүлсэн.

3.8. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 144.3 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 1 зөвлөмж өгсөн ба биелэлтийг ирүүлсэн байна. Давтан шалгаж үзэхэд албан шаардлагыг хэрэгжүүлж, зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Хүснэгт: №9 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		/сая төгрөг/ Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт							
Албан шаардлага	2	144.3	2	144.3			100
Зөвлөмж	1				1		0
Нийт	3	144.3	3	144.3	1		

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 10 төсвийн байгууллага, 4 тусгайн сангийн нийт 14 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 8 байгууллагад дүгнэлт гаргаж, 2 байгууллага, нэгжийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудаас Засаг даргын тамгын газар, Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль, 2 дугаар сургууль, 3 дугаар сургууль, 4 дүгээр сургууль, Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайланд “Зөрчилгүй” дүгнэлт, Хүүхдийн 2 дугаар цэцэрлэгт “хязгаарлалттай” дүгнэлт өгсөн байна.

Сумын ИТХ, Соёлын төв, Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сан, Эргэлтийн эмийн сангийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулж үзсэн.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар алдаа зөрчил гараагүй байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлантай холбоотой залруулга хийгдээгүй байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага:

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангаар ОНХСан болон Сум хөгжүүлэх сангийн шилэн данстай холбоотой 489.3 сая төгрөгийн 1 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлсэн.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 1446.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс сумын төсөвт байгууллагын дүнгээр 14.6 сая төгрөгийн 2 залруулга хийгдэж, 0.2 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 609.4 сая төгрөгийн зөрчилд 10 албан шаардлага, 822.0 сая төгрөгийн зөрчилд 8 зөвлөмж хүргүүлсэн байна.

Хүснэгт №10: Төсөвт байгууллагуудын алдаа зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ЗДТГ	1	14.9					1	14.9		
2	Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль	2	28.3					1	7.1	1	21.2
3	Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль	2	0.7			1	0.2	1	0.5		
4	Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль	3	66.5					3	66.5		
5	Ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль	4	9.1	1	1.3			1	0.7	2	7.1
6	Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэг	3	396.8					1	4.1	2	392.7
7	Хүүхдийн 2 дугаар цэцэрлэг	3	530.3					2	515.6	1	14.7
8	Эрүүл мэндийн төв	3	399.6	1	13.3					2	386.3
Нийт дүн		21	1446.2	2	14.6	1	0.2	10	609.4	8	822.0

3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

1. Албан тушаалын чиг үүргийн хэрэгжилттэй холбоотой асуудал:

1.1. Илрүүлэлт:

Сумын Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сангийн 2 дугаар гарын үсгийг сангуудыг хариуцаж байгаа мэргэжилтэн нар зурж, тайлан баланс гаргаж ирүүлсэн байна.

Энэ нь Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн 42 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан Санхүүгийн албаны даргын ажлын байрны тодорхойлолтын албан тушаалын 2 дугаар зорилтын 12, 3 дугаар зорилтын 1-д заасныг зөрчсөн байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн 42 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан сумын Санхүүгийн албаны ажлын байрны тодорхойлолтод заасны дагуу Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сангуудын 2 дугаар гарын үсгийг санхүүгийн албаны даргаар зуруулж, тайлан, баланс гаргуулах зөрчлийг арилгаж ажиллах;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын газарт 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

/сая төгрөг/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Ногооннуур сумын ТТЗСНТайлан	2	489.3					1	489.3	1	